



РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 35.1, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3, MNS 4969:2002 стандарт, "Радио телевизийн үндэсний сүлжээ" Улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын харьяа ажлын байранд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны үзлэг хяналт явуулах, зааварчилгаа өгөх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 3 шатны хяналт явуулах хуваарь"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар (Ц.Ганзориг), Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Б.Уртнасан) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан захирлын 2009 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 66 дугаартай тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ  БАГВАСҮМБЭРЭЛ



16240100-9

“Радио телевизийн үндэсний сүлжээ”
Улсын төсөвт үйлдвэрийн газрын
2024 оны 12 дугаар сарын 8 өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ГУРВАН ШАТНЫ ҮЗЛЭГ ХЯНАЛТ ЯВУУЛАХ, ЗААВАРЧИЛГАА ӨГӨХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. “Радио Телевизийн Үндэсний Сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын нийт алба, нэгж, салбаруудын ажлын байрны нөхцөл, барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмжийн стандарт, тэдгээрийн холболт угсралт, урсгал засвар, үзлэг үйлчилгээ, тохиргоо, тосолгооны ажлыг журмын дагуу хийж буй эсэх, аюултай тэсэрч дэлбэрэх бодис байгаа эсэх түүнтэй хэрхэн харьцах, тээвэрлэлт хийх машины бүрэн бүтэн байдал, галын аюулгүй байдал, ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл, техник технологийн горимд тавигдах шаардлага стандартад хэрхэн хандаж хэрэгжүүлж байгааг шалгаж, зөрчил дутагдлыг цаг тухайд нь илрүүлэн арилгаж байх зорилгоор “Гурван шатны хяналт”-ын ажлыг зохион байгуулах, Монгол улсын MNS 4969 2002 тоот стандартын норм нормативын шаардлагыг биелүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Гурван шатны хяналтыг тогтоосон хугацаанд нь явуулж, зааварчилгааг тогтмол өгч ажиллах нь байгууллагын захиргаа, албан хаагч нараас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх ажлын үндсэн арга хэлбэр юм.

1.3. Гурван шатны хяналтыг байгууллагын ажилтан, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл болон Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ажилтан, Үйлдвэрчний эвлэлийн хорооны гишүүдийн төлөөлөл оролцсон комисс хийнэ.

1.4. Гурван шатны хяналтын үр дүнг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтын журналд тэмдэглэн үлдээнэ.

1.5. Байгууллагын алба нэгжийн бүтэц ажлын онцлогтой уялдуулан дараах албан тушаалтнууд гурван шатны хяналтыг хийнэ.

- 1-р шатны хяналтыг тухайн хяналт хийх хуваарьт өдрийн ээлжийн ахлагч, ээлжийн инженер эсвэл орлож буй ажилтан
- 2-р шатны хяналтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер, ахлах инженер
- 3-р шатны хяналтыг байгууллагын даргын тушаалаар томилогдсон комисс

ХОЁР. НЭГДҮГЭЭР ШАТНЫ ХЯНАЛТ

2.1. Ээлжийн ахлах, ажлыг шууд удирдаж буй ажилтан тус тусын хариуцсан үүргийн дагуу ажлын байранд болон ажлын явцад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ба

хөдөлмөрийн нөхцөлийн байдалд анхан шатны хяналт хийх ба долоо хоногийн Даваа гарагт ээлжийн ахлах нэгдсэн үзлэгийг хийнэ.

2.2. Ажилтан ажил эхлэхийн өмнө ажлын байрандаа эрсдэлийн үнэлгээ хийж хяналтын журналд тэмдэглэнэ.

2.3. Нэгдүгээр шатны хяналтаар дараах зүйлийг шалгана.

- Ажлын байрны эмх цэгц
- Ариун цэвэр
- Тоног төхөөрөмжийн газардуулга
- Удирдлага дохиоллын бүрэн бүтэн байдал
- Хамгаалах хэрэгслийн норм хугацаа, баталгаажилт,
- Цахилгааны монтаж, оруулгын аюулгүй байдал
- Ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх
- Галын аюулгүй ажиллагааны хэрэгжилт багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал
- Анхан шатны бүртгэл хөтлөлтийн чанар
- Өмнөх үзлэгээр илэрсэн зөрчил арилгасан эсэх
- Ажлын хувцас хамгаалах хэрэгслийн норм хугацаа ашиглалтын байдал
- Тоног төхөөрөмжийн хөдөлгөөнтэй хэсгийн хаалт хамгаалалт бүрэн эсэх

ГУРАВ. ХОЁРДУГААР ШАТНЫ ХЯНАЛТ

3.1. Байгууллагын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн, салбар нэгжийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан инженерүүд графикийн дагуу сард 1-2 удаа хяналт хийх ба шаардлагатай үед удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2-р шатны хяналт хийнэ.

3.2. Хоёрдугаар шатны хяналтаар дараах зүйлийг шалгана.

- Өмнөх үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгасан байдал
- Ажлын байрны эмх цэгц, ариун цэвэр
- Тоног төхөөрөмжийн газардуулга, удирдлага дохиоллын бүрэн бүтэн байдал
- Хамгаалах хэрэгслийн норм хугацаа, баталгаажилт
- Цахилгааны монтаж оруулгын аюулгүй байдал
- Ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх
- Галын аюулгүй ажиллагааны хэрэгжилт, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал
- Анхан шатны бүртгэл хөтлөлтийн чанар
- Инженер, техникийн ажилтан нарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг мөрдөж буй эсэх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон байгууллагын дүрэм, журмын мөрдөлт хангалттай эсэх
- Барилга байгууламжийн аюулгүй байдал

- Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал
- Графикт засвар үйлчилгээ тосолгоо, тохиргоо хийж хэвшсэн байдал түүний тэмдэглэл /Техникийн паспорт, журналууд/
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй ба галын аюулгүй ажиллагааны дохио санамж бүрэн бүтэн шаардлага хангаж буй эсэх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар сургалт, сурталчилгаа өгөгдөж буй эсэх
- Ажлын байранд ажилтны эрүүл мэнд амь насанд заналхийлсэн зүйл байгаа эсэх
- Ажилтанд яаралтай эмнэлгийн тусламж үзүүлж чадаж буй эсэх шаардлагатай хангалтыг олгосон байдал
- 2-р шатны хяналтын талаар хяналтын журналд тэмдэглэж зөрчлийг хэрхэн арилгасан байдлыг тайлантай тулган тохирч буйг үзэх.

ДӨРӨВ. ГУРАВДУГААР ШАТНЫ ХЯНАЛТ

4.1. Байгууллага дээр мөрдөгдөж байгаа тушаал, шийдвэрийн дагуу байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн гишүүд, Үйлдвэрчний эвлэлийн хороо, ажилтны төлөөлөл оролцсон комиссыг даргын тушаалаар баталгаажуулан томилж улиралд нэг удаа хийнэ.

Гуравдугаар шатны хяналтаар дараах зүйлийг шалгана.

- 1, 2-р шатны хяналтыг хугацаанд нь чанартай хийсэн эсэх, зөрчлийг арилгасан эсэх
- Барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин техник, тээврийн хэрэгсэл, даралтат сав, уурын зуух, цахилгааны эх үүсгүүр, өргөх буулгах төхөөрөмжийн арчилгаа, техникийн паспорт, бичиг баримтын хөтлөлт шаардлага хангаж буй эсэх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, галын аюулгүй ажиллагааны сургалт хийгдсэн, шалгалт авсан эсэх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар, зааварчилгаа цаг тухайд нь хийдэг буй эсэх
- Ажлын хувцасны ашиглалт, норм, чанар шаардлага хангаж буй эсэх
- Ажилтны ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолттой эсэх
- Ажлын байрны тав тух, гэрэлтүүлэг, агааржуулалт, сөрөг нөлөөлөл байгаа эсэх
- Ажилтан ажиллах явцад ёс суртахууны болон ажлын байрны дарамтад өртөх зэрэг сөрөг нөлөөлөл байгаа эсэх

4.2. 3-р шатны хяналт хийсэн комисс нь илэрсэн зөрчил дутагдлын дагуу зөвлөмжийг хүргүүлнэ. Зөрчил арилгах үүрэг авсан ажилтан өгөгдсөн хугацаанд зөрчлийг арилгасан тайлан үйлдэж Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.

4.3. Уг комисс нь илэрсэн зөрчлийн дагуу акт үйлдэж салбар, нэгжид хүргүүлэх ба 14 хоногийн дотор хариу тайланг авч биелэлтийн талаар захирлын зөвлөлд танилцуулна.

4.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны хяналтын талаар дүгнэлт гаргаж шаардлагатай бол шагнах урамшуулах, хариуцлага тооцох зэрэг арга хэмжээг авна.

ТАВ. ЗААВАРЧИЛГАА ӨГӨХ

Монгол улсын MNS 4969 2002 тоот стандартын норм нормативын шаардлагыг биелүүлэх үүднээс учирч болох эрсдэлийн талаарх мэдээллийг бусдад хуваалцаж анхааруулга сануулга өгөхөд гол зорилго оршино. Ажил хийж байгаа ажилтан бүрд эрсдэл тохиолдож болох учир өөрийнхөө төлөө болон хамтран ажиллаж байгаа ажилчдынхаа төлөө зааварчилгаад оролцох нь ажилтан бүрийн үүрэг юм.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа дараах гурван хэлбэртэй байна. Үүнд:

- **Урьдчилсан зааварчилгаа**
- **Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа**
- **Давтан зааварчилгаа**

5.1. **Урьдчилсан зааварчилгаа:** Шинээр ажилд орсон ажилтан, үйлдвэрлэлийн дадлага сургалт хийхээр ирсэн оюутан, суралцагчдад тэдний ажилласан жил боловсролын түвшнийг харгалзахгүйгээр урьдчилсан зааварчилгааг өгнө.

5.1.1. **Урьдчилсан зааварчилгааны агуулга:** Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Монгол улсын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт, “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын хөдөлмөрийн дотоод дүрэм, журам, хамтын гэрээ, техникийн аюулгүй ажиллагааны заавар, галын аюулгүй байдал, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлого үүсэх шалтгаан, осолдогчдод үзүүлэх анхны тусламж зэрэг багтана.

5.1.2. **Урьдчилсан зааварчилгааг** хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан өгнө.

5.2. **Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа:** Ажлын байран дахь анхан шатны зааварчилгааг ажилтнуудын ажилладаг хэсэг, салбар, нэгжүүдэд ажлын байр өөрчлөгдөх үед мөн шинээр ажилд орсон болон үйлдвэрийн дадлага хийхээр ирж урьдчилсан зааварчилгаа авсан оюутан сурагчид, ажилчдад өгнө.

5.2.1. **Ажлын байран дахь анхан шатны зааварчилгааны агуулга:** Ажлын байрны үйлдвэрлэлийн процесс, гүйцэтгэх ажлын онцлог, машин техник, багаж, хэрэгсэл ашиглах

болон ажлын явцад үүсэж болох сөрөг хүчин зүйл, түүнээс хамгаалах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах заавар, үйлдвэрлэлийн машин механизм, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны болон галын аюулгүй ажиллагааны шаардлага, галын аюулгүй байдлыг хангах журам, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах, хадгалах, осолдогчдод үзүүлэх анхны тусламж зэрэг багтана.

5.2.2. Ажлын байран дахь анхан шатны зааварчилгааг тухайн ажлын байрыг хариуцсан салбар, нэгжийн дарга, ахлах инженер биечлэн үзүүлэх журмаар өгнө.

5.2.3. Ажлын байран дахь анхан шатны зааварчилгааг авсан ажилтнаас шалгалт авч хангалттай гэж үзвэл уг ажилтанд бие даан ажиллах зөвшөөрөл олгоно.

5.3. Давтан зааварчилгаа: Ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор ажлын байран дахь анхан шатны зааварчилгааны агуулгаар өгнө.

Давтан зааварчилгаа нь гурван хэлбэртэй. Үүнд:


- **Ээлжит**
- **Ээлжит бус**
- **Ажлын байран дахь өдөр тутмын**

5.3.1. Ээлжит давтан зааварчилгааг улиралд нэгээс доошгүй удаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан өгнө.

5.3.2. Ээлжит бус давтан зааварчилгааг шинэ технологи нэвтрүүлэх, машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл шинээр суурилуулах, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журам шинэчлэгдэх үед давтан зааварчилгааг ээлжит хугацаанаас нь өмнө өгнө. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, зааврыг ноцтой зөрчсөн хүмүүс буюу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого гарсан салбар, нэгжийн ажилчдад, мөн нэг сараас илүү хугацаагаар ажлаас хөндийрч яваад эргэж ажилдаа орсон ажилтанд ээлжит бус давтан зааварчилгааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн өгнө.

5.3.3. Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгааг аюултай ажил гүйцэтгэдэг ажилчдад тухайн алба нэгжийн ахлах инженерүүд өгнө. Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа нь товч тодорхой байх ба ажил эхлэхийн өмнө бичгээр өгч гарын үсэг зурж баталгаажуулна. Ажил эхлэхийн өмнө нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зөв зохистой өмссөн байдлыг алба, нэгжийн ахлагч нар биечлэн үзэж, шалгаж ажилд гаргана.

“Радио телевизийн үндэсний сүлжээ”
Улсын төсөвт үйлдвэрийн газрын
2024 оны 3 дугаар сарын 1 өдрийн
3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
3 шатны хяналт хийх хуваарь

| Хяналтын төрөл | Хяналт хийх хугацаа | Хяналтаар үзэх зүйлүүд | Хяналт хийх албан тушаалтан |
|--|--|--|--|
| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 1-р шатны хяналт | Долоо хоног бүрийн ДАВАА гарагт | Ажлын байрны эмх цэгц, ариун цэвэр, тоног төхөөрөмжийн газардуулга, удирдлага дохиоллын бүрэн бүтэн байдал, хамгаалах хэрэгслийн норм хугацаа, баталгаажилт, цахилгааны монтаж оруулгын аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх. Галын аюулгүй ажиллагааны хэрэгжилт багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, Анхан шатны бүртгэл хөтлөлтийн чанар | Ээлжийн ахлагч нар ажлын байраар явж хийнэ. |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 2-р шатны хяналт | Сар бүрийн 2,4 дэх долоо хоногийн ЛХАГВА гарагт | Өмнөх үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгасан байдал. Ажлын байрны эмх цэгц, ариун цэвэр, тоног төхөөрөмжийн газардуулга, удирдлага дохиоллын бүрэн бүтэн байдал, хамгаалах хэрэгслийн норм хугацаа, баталгаажилт, цахилгааны монтаж оруулгын аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх, Галын аюулгүй ажиллагааны хэрэгжилт багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэх машины бүрэн бүтэн аюулгүй эсэх. Анхан шатны бүртгэл хөтлөлтийн чанар | Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн болон салбаруудын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан инженер |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 3-р шатны хяналт | Жилд нэг удаа /Шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт хугацаанаас өмнө болон давтамжийг нэмж хяналт хийнэ./ | Хяналтын хуудасны дагуу үзлэг хийнэ. | Байгууллагын даргын нэрэмжит хяналт учраас даргын тушаалаар комисс томилогдон ажиллана. |